

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ УУЛ УУРХАЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА
ГҮНЧИНСҮРЭНГИЙН НАМЧИНСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

№	Д/д	Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, АҮЭБЯ-ны стратеги төлөвлөгөө (2024-2028)	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Гүйцэтгэлийн хувь
Зорилго 2. Эрдэс баялгийн салбарын (геологи, уул уурхай, газрын тос, цөмийн энерги) салбарын хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлагаар хангана.								
Зорилт 1. Геологи, уул уурхай, газрын тос, цөмийн энергийн салбарыг хөгжүүлэх бодлого, урт, дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулна:								
1.	2.1.1	Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, ЗГ-ын хуралдаанд танилцуулахаар хүргүүлэх.	Улсын төсөв	Хүргүүлс эн эсэх. (Тийм:1, Үгүй:0)	0	1	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон тус хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулсан Цөмийн энергийн тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын 2025 оны 03 дугаар 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон.	

						Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлсэн. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025 оны 04 дүгээр сарын 17-ний өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлсэн. УИХ дахь МАН-ын болон АН-ын бүлгийн 2025 оны дөрөвдүгээр сарын 21-ний өдрийн ээлжит хуралдаанаар Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг танилцуулж хэлэлцүүлсэн. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 04 дугаар 23-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслийг эргүүлэн татах шийдвэрийг гаргасан. Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улсын хамтарсан хөрөнгө оруулалттай “Гурвансайхан” ХХК-ийн цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг шийдвэрлэх зорилгоор “Ашигт малтмалын зарим тусгай зөвшөөрлийн тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, яамдаас саналыг авч 2025 оны 02-р сарын 14-ний өдрийн 01/478 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Тус материалын хүрээнд Засгийн газрын 2025 оны 13 дугаар хуралдааны тэмдэглэл гарч “Гурвансайхан” ХХК-ийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг шийдвэрлэхийг АМГТГ-т даалгасан.	
--	--	--	--	--	--	--	--

						Газрын ховор элемент болон чухал ашигт малтмалын талаар Засгийн газрын 2025.02.26-ны өдрийн хуралдаанд танилцуулж, хуралдааны 10 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. Чухал ашигт малтмалын жагсаалтыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Үндэсний геологийн албаны даргын 2025.10.29-ний өдрийн А/57 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж байна. -Зөвшөөрлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан цацрагийн үүсгүүрийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлсэн. - Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон тус хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулсан Цөмийн энергийн тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 03-р сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хуралд 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн. - Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улсын хамтарсан хөрөнгө оруулалттай “Гурвансайхан” ХХК-ийн цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг шийдвэрлэх зорилгоор “Ашигт малтмалын зарим тусгай зөвшөөрлийн тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, яамдаас саналыг авч 2025 оны 02-р сарын 14-ний өдрийн 01/478 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Тус материалын хүрээнд	
--	--	--	--	--	--	--	--

							Засгийн газрын 2025 оны 13 дугаар хуралдааны тэмдэглэл гарч “Гурвансайхан” ХХК-ийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг шийдвэрлэхийг АМГТГ-т даалгасан. - Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төсөл болон тус хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулсан Цөмийн энергийн тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Эдийн засаг, хөгжлийн сайдад хүргүүлсэн.	
Зорилт 2. Эрдэс баялгийн салбар (геологи, уул уурхай, газрын тос, цөмийн энерги)-ын хууль, тогтоомжийг боловсронгуй болгон шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулна:								
2.	2.2.1	Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах.	Улсын төсөв	Боловсруулсан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Эрдэс баялгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын 2025.03.19-ний өдрийн хуралдаанд танилцуулж, хуралдааны 13 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. Улсын Их Хурлын даргын Захирамжаар байгуулагдсан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар танилцуулсан. Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 16 өдрийн хуралдаанд танилцуулсан. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж, УИХ дахь Ажлын хэсэгт хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн.	100

							Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд 2025.11.28-ны өдөр хүргүүлсэн.	
3.	2.2.2	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах.	Улсын төсөв	Боловсруулсан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг АҮЭБСайдын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/18 дугаар тушаалаар байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр боловсруулан батлуулж, Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулсан. Хуулийн төслийг эхний байдлаар боловсруулсан. Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, үр нөлөөллийн үнэлгээний төсөл боловсруулж, Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулан аж ахуй нэгжүүдээс санал авч байна.	90
4.	2.2.3	Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах.	Улсын төсөв	Боловсруулсан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг АҮЭБСайдын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/18 дугаар тушаалаар байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр боловсруулан батлуулж, Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулсан. Хуулийн төслийг эхний байдлаар боловсруулсан. Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, үр нөлөөллийн үнэлгээний төсөл боловсруулж, Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулан ажиллаж Хуулийн төслийг эхний байдлаар боловсруулсан. Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулж, санал авч байна. Мөн үзэл баримтлалын төсөл боловсруулах явцад нэмэлт, өөрчлөлт биш шинэчилсэн	90

							найруулга болсон тул Ажлын хэсэг хуулийн төсөл дээр ажиллаж байна.	
5.	2.2.4	Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах.	Улсын төсөв	Боловсруулсан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Эрдэс баялгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын 2025.03.19-ний өдрийн хуралдаанд танилцуулж, хуралдааны 13 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. Улсын Их Хурлын даргын Захирамжаар байгуулагдсан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар танилцуулсан. Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 16 өдрийн хуралдаанд танилцуулсан. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж, УИХ дахь Ажлын хэсэгт хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд 2025.11.28-ны өдөр хүргүүлсэн.	100

Зорилт 3. Улсын хэмжээнд тогтоогдсон эрдэс баялгийн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах, үйлдвэрлэл явуулахад шаардагдах дэд бүтцийг төлөвлөх, баялгийн өгөөжийг хуваарилах бодлогыг тодорхойлох, бодлогын удирдамжаар хангах, санал, зөвлөмж боловсруулна:

6.	2.3.1	Монгол Улсын Засгийн газар болон Орано майнинг САС хооронд хөрөнгө оруулалтын гэрээг байгуулж, Зөөвч-Овоо, Дулаан-Уул ураны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах дэд бүтцийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг хангах.	Улсын төсөв	Ордыг ашиглах гэрээг байгуулсан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	ЗГХЭГ-ийн даргын 2024.09.10-ны өдрийн 93 дугаар тушаалаар Монгол Улсын Засгийн газар болон Орано майнинг САС хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд санал, дүгнэлт боловсруулж, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий “Олборлолт, үйлдвэрлэл, технологийн асуудал хариуцсан ажлын дэд хэсэг”-ийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаар ахлуулан байгуулсан. Ажлын дэд хэсэг 2024 оны 12-р сард 2 удаа хуралдаж, уг гэрээний төсөлд өгөх дэд ажлын хэсгийн санал, дүгнэлтийг боловсруулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024.12.12-ны өдрийн 01/1301 дугаар, 2024.12.30-ны өдрийн 01/1463 дугаар албан бичгээр тус тус саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Ажлын хэсэг Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Орано майнинг САС хооронд байгуулах “Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Засгийн газрын 2025.01.08-ны өдрийн хуралдаанд танилцуулсан бөгөөд Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцсөн тухай УИХ-ын 2025.01.10-ны өдрийн 02 дугаар тогтоол гарсан. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц улсын Орано майнинг С.А хооронд “Хөрөнгө оруулалтын гэрээ”-нд гарын үсэг зурах эрх олгох тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын 2025.01.14-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор батлуулсан. Уг тогтоолын дагуу Хөрөнгө оруулалтын гэрээнд 2025.01.17-ны өдөр талууд гарын үсэг зурсан. Хувьцаа эзэмшигчдийн гэрээ болон Орд ашиглах гэрээг Хөрөнгө оруулалтын гэрээнд нийцүүлэн шинэчилж төслийг эцэслэн	100
----	-------	--	-------------	---	---	---	--	-----

						боловсруулж, 2025 оны 3 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Засгийн газрын 2025 оны 28 дугаар тогтоолоор ЗГХЭГ болон “Эрдэнэс Монгол” ХХК-д даалгасан бөгөөд Ерөнхий сайдын 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 57 дугаар захирамжийн дагуу Орд ашиглах гэрээний төслийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаар ахлуулсан Ажлын хэсэг эцэслэн боловсруулж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025.09.04-ний өдрийн 01/2520 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2025.09.10-ны өдрийн хуралдаанд танилцуулсан бөгөөд холбогдох саналуудыг тусгаж эцэслэн боловсруулах чиглэлийг өгсөн. ЗГ-аас өгсөн чиглэлийн дагуу ажиллаж боловсруулсан орд ашиглах шинэчилсэн гэрээний төслийг эцэслэж, “Гэрээнд гарын үсэг зурах тухай Засгийн газрын тэмдэглэлийн төслийг боловсруулж, яамдаас санал авахаар 2025.11.18-ны өдрийн 01/3280 дугаар албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025.11.17-ны өдрийн 01/3363 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Цөмийн энергийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсэг, Хөрөнгө оруулалтын гэрээнд заасны дагуу Мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авч, саналыг тусган холбогдох материалын хамт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 01/3264 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т	
--	--	--	--	--	--	--	--

							хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын тогтоол гарсан.	
7.	2.3.2	“Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын төсөлтэй холбогдуулан “Гурвыг цогцоор” хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах.	Улсын төсөв	Хэлэлцээр байгуулагдсан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Улсын Их Хурлын 2024 оны 58 дугаар тогтоолыг баримтлан боловсруулсан “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөлд Монгол Улсын Ерөнхий сайд, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд нар 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр БНХАУ-ын Харбин хотноо гарын үсэг зурсан. Улмаар “Гашуунсухайт–Ганцмод” хил дамнасан төмөр замын төсөлтэй холбогдуулан “Гурвыг цогцоор” хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах чиглэлээр төлөвлөсөн ажлын хэрэгжилтийг ханган ажилласны үр дүнд Улсын Их Хурлын 2025.03.27-ны өдрийн чуулганы хуралдаанаар Гашуунсухайт–Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа болон Тавантолгойн уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулсан.	100
8.	2.3.3	Стратегийн ордуудаас Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх талаар санал боловсруулах.	Улсын төсөв	Санал боловсруулсан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	- Стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах: Гачуурт (75.9 тн), Эрээн–Баавгайн (14.6 тн), Шургадагийн голын (3.2 тн) алтны ордуудын ашиглалтыг эхлүүлэх шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2025.04.30-ны 211 дүгээр тогтоол батлагдав.	100

							Эдгээр ордууд ашиглалтад орсноор жилд 4 тн алт Монголбанкинд тушаах боломж бүрдэнэ. - “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн орлого, үр ашгийг нэмэгдүүлэх: Нүүрс баяжуулах үйлдвэрийн ашиглалтад хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж, 10 сая тн/жил хүчин чадалтай үйлдвэр 2025.05 сард ашиглалтад орсон. Төсөл хэрэгжих хугацаанд улсын төсөвт 15.9 их наяд төгрөг төвлөрөх боломж бүрдсэн. - “Бадрах Энержи” ХХК – Ураны төслийн үр ашиг: Монгол–Францын хөрөнгө оруулалтын гэрээг УИХ-тай зөвшилцүүлж батлуулсан. Төслийн хугацаанд улсын төсөвт жилд дунджаар 140.4 сая ам.доллар, нийтдээ: АМНАТ: 1.7 тэрбум ам.доллар ОАТ: 1.57 тэрбум ам.доллар Давуу эрхтэй хувьцаа: 477 сая ам.долларын өгөөжийг өгсөн. -“Оюу толгой” төслийн үр ашгийг нэмэгдүүлэх хэлэлцээ: Далд уурхайн бүтээн байгуулалт 98.7% гүйцэтгэлтэй; жилд 8 их наяд төгрөг улсын төсөвт төвлөрөх тооцоо гарсан. Хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах, менежментийн төлбөрийг шинэчлэх асуудлаар ажлын хэсэг байгуулж: Зээлийн хүүг бууруулах талаар протоколд гарын үсэг зурсан Менежментийн төлбөрийг олон улсын жишигт нийцүүлэхээр тохирсон Хөндлөнгийн аудитын ажлын даалгавар боловсруулсан. -“Онтре” ХХК болон тусгай зөвшөөрлийн асуудал:	
--	--	--	--	--	--	--	---	--

						Компани хоорондын ашиг хуваах гэрээ, арбитрын мэдээллийг УИХ-ын Байнгын хороонд танилцуулж, Монголын талын өгөөжийг тооцсон санал, хувилбаруудыг боловсруулж хүргүүлсэн. -УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилт: Тус тогтоолд заасан ашигт малтмалын ордуудын мэдээллийг нэгтгэж Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Засгийн газрын 2025.04.09-ний өдрийн 16 дугаар тэмдэглэл гарсан. -Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 68 дугаар захирамжаар “Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах, хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, төслийг тохирон эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах” үүрэг бүхий ажлын хэсгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд ахлан ажиллаж байна. -Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар Стратегийн ач холбогдол бүхий Оюутолгойн бүлэг ордын талбайн хил зааг дотор ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг “Онтрэ” компанийн хувьцааны төрийн эзэмших хувь хэмжээг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох талаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, холбогдох бусад асуудлыг Монгол Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд ахлан ажиллаж байна.	
--	--	--	--	--	--	--	--

							-Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67, 68, 73 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгүүдийн хүрээнд хэлэлцээ хийх багийн бүрэлдэхүүн, хэлэлцээнд баримтлах удирдамжийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2025.10.29-ний өдрийн 149 дүгээр тогтоолоор батлуулсан. Улмаар Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 68 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд Рио Тинто компанитай хэлэлцээ хийх ажил явагдаж байгаа бөгөөд Менежментийн үйлчилгээний төлбөрийн нөхцөлийг бууруулах талаар талууд хүчин чармайлт гаргахаар харилцан тохиролцож, 2025.10.30-ны өдөр протоколд гарын үсэг зурсан. Хэлэлцээ үргэлжилж байна. Монгол Улсын Ерөнхий Сайдын 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 72 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу олгогдсон эсэхийг шалгаж, дүгнэлт гаргах” үүрэг бүхий дэд ажлын хэсэгт ажиллаж холбогдох мэдээллийг хүргүүлсэн.	
9.	2.3.4	Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалдаг бүтээгдэхүүний нэр төрөл, экспортын орлогыг нэмэгдүүлэх талаар эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулах.	Улсын төсөв	Санал боловсруулсан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/56 дугаартай тушаалаар Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад тулгамдаж буй асуудлаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр хуралдаж Уул уурхайн бүтээгдэхүүний дотоодын биржийн арилжааны	100

						журмын төслийг хэлэлцэж, холбогдох саналуудыг тусгахаар тогтсон. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын 2025 оны 03 дугаар 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон. Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 16-ний өдрийн хуралдаанаар Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлсэн. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025 оны 04 дүгээр сарын 17-ний өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлсэн. УИХ дахь МАН-ын болон АН-ын бүлгийн 2025 оны дөрөвдүгээр сарын 21-ний өдрийн ээлжит хуралдаанаар Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг танилцуулж хэлэлцүүлсэн. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 04 дугаар 23-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслийг эргүүлэн татах шийдвэрийг гаргасан. Засгийн газрын 2023 оны “Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл ангиллыг батлах	
--	--	--	--	--	--	--	--

							тухай” 223 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2025.03.12-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор батлуулсан. “Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн олборлолт, боловсруулалт, баяжуулалтын явцад бий болсон агуулга багатай хүдэр, ашигт малтмалын овоолгыг баяжуулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортод гаргах үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2025.05.28-ны өдрийн 275 дугаар тогтоолоор батлуулсан. Засгийн газрын 2025.08.20-ны өдрийн 55 дугаар тогтоолоор Ашигт малтмал экспортлогч аж ахуйн нэгж нь тухайн төрлийн экспортын бүтээгдэхүүний дөрөвний нэг, түүнээс дээш хувийг Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалсан тохиолдолд нийт экспортод гаргасан тухайн төрлийн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээг “Биржийн болон зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр зарлах тухай” Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 81 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтад заасан Уул уурхайн бүтээгдэхүүний бирж (Монголын хөрөнгийн бирж)-ийн арилжааны үнээр тооцож, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулахаар батлуулсан.	
Зорилт 4. Эрдэс баялгийн салбар (геологи, уул уурхай, газрын тос, цөмийн энерги)-ын хэмжээнд мөрдөх дүрэм, журам, ангилал, заавар, шаардлага, зөвлөмжийн төсөл боловсруулж, батлуулна:								
10.	2.4.1	Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, зөвлөмж,	Улсын төсөв	Боловсруулсан	0	3	Газрын тосны бүртгэл тооцооны журамд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг АҮЭБСайдын 2025 оны 06	100

		норм норматив, стандарт, аргачлал, маягтыг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулах.		төслийн тоо			дугаар сарын 04-ний өдрийн А/144 дүгээр тушаалаар байгуулсан. Засгийн газрын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан АҮЭБСайдын тушаалыг 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/194 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулав. Журмын төслийг боловсруулан ААН, олон нийтээс саналыг авч, Ажлын хэсэг журмын төсөлд тусгаж ажиллав. Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-д нэмэлт өөрчлөлт оруулах журмын төслийг боловсруулан, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолоор баталсан "Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр, төрөл, ангилал"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг холбогдох материалын хамт 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/631 дугаартай албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор "Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр, төрөл, ангиллыг батлах тухай" Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 223 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж батлуулсан. Засгийн газрын 2011 оны 193 дугаар тогтоолоор баталсан Ашигт малтмалын хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг	
--	--	---	--	-------------	--	--	---	--

							боловсруулж, Засгийн газрын 2025.03.19-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Геологийн салбарын хэмжээнд даган мөрдөж буй хүчин төгөлдөр захиргааны акт буюу дүрэм, журам, заавар, шаардлагын судалгааг хийж, жагсаалт гаргасан: Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг хүлээн авах журамд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулж Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/84 дүгээр тушаалаар батлуулсан. Сайдын тушаалаар журамд нэмэлт, өөрчлөлт оруулсныг Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр хуульд заасан баримтын бүрдлийг ханган Хууль зүй, дотоод хэргийн сайдад 2025 оны 1/1396 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 1/2665 дугаар албан бичгээр нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний улсын бүртгэлд бүртгэсэн тухай мэдэгдсэн. Журмын нэмэлт өөрчлөлтийг даган мөрдүүлэхээр ТНБДарыгн 2025 оны 02/1542 дугаар албан бичгээр УГА-нд мэдэгдсэн. -ТНБДаргын 2024.11.19-ний өдрийн А/57 дугаар тушаалаар “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсантай холбогдуулан чиг үүргийн дагуу санал хүргүүлсэн. -Үүсмэл (техноген) ордын геологийн судалгаа, нөөцийн тооцоолол болон Дагалдах ашигт малтмалын геологийн судалгаа, нөөцийн тооцооллын аргачилсан зөвлөмжийг боловсруулсан. Тус 2 аргачилсан зөвлөмж хүлээн авах тухай АҮЭБС-ын тушаалыг	
--	--	--	--	--	--	--	--	--

							боловсруулан 2025.03.07-ны өдрийн А/47 дугаартай тушаалаар батлуулсан. “Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх 1:25000 болон түүнээс дээш том масштабын геоэкологи гидрогеологийн судалгааны ажил гүйцэтгэх заавар”-ын төслийг ЭБМЗ-ийн 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, хүлээн авч батлуулахаар дүгнэлт гарсан.	
Зорилт 5. Эрдэс баялгийн салбар (геологи, уул уурхай, газрын тос, цөмийн энерги)-т хэрэгжүүлэх гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, арга хэмжээг нэгдсэн удирдлага, бодлого, төлөвлөлтөөр хангана:								
11.	2.5.1	Засгийн газар хоорондын комисс болон дэд комиссын хуралдаанд оролцох, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.	Улсын төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	3	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т заасан Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд хэлэлцээр байгуулах комиссын БНХАУ болон МУ-д хуралдаануудад холбогдох мэдээллийг боловсруулж тухай бүр оролцон ажилласан. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын Газрын хэвлийн ашиглалтын хамтарсан дэд комиссын хуралдааныг 2025.05.16, 2025.12.09-ний өдөр цахимаар зохион байгуулж, өмнөх хуралдаануудаар хэлэлцсэн асуудлын хэрэгжилтийг хэлэлцсэн. Үүнд: 1.Росгеологи ХН, Үндэсний геологийн алба хооронд хамтран ажиллах тухай санамж бичгийг 2025.01.24-ний өдөр байгуулсан. 2.Хилийн бүсийн геохимийн судалгааны ажлыг гүйцэтгэх ажилд Монголын талаас 3 геохимич, Оросын талаас 3 геохимич ажиллахаар бэлтгэл ажлыг эхлүүлсэн.	100

							3.Өсвөрийн геологичдын олимпиадыг 2025.06.28-2025.07.05-ны өдрүүдэд Монгол Улсад Горхи-Тэрэлжийн цогцолборт газарт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Монголын талаас 10 хүний бүрэлдэхүүнтэй 5 баг, шүүгчдийн бүрэлдэхүүнд 9 эрдэмтэн, зохион байгуулалтад 15 орчим хүн оролцож ажилласан. 4. Карпинскийн нэрэмжит Геологийн танхимыг Геологийн хүрээлэнгийн шинэ байранд нээх тухай албан бичгийг ЭЗХЯ-нд хүргүүлсэн. 5. ОХУ-ын Анапа хотод 2025.08.08-2025.08.28-ны өдрүүдэд болсон Геологичдын ээлж солилцооны хөтөлбөрт 4 сурагч, 1 багшийн оролцоог ханган, оролцох бүх талын дэмжлэг үзүүлж ажилласан. 6.Өсвөрийн геологичдын олимпиадыг 2025.06.28-2025.07.05-ны өдрүүдэд Монгол Улсад Горхи-Тэрэлжийн цогцолборт газарт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Монголын талаас 10 хүний бүрэлдэхүүнтэй 5 баг, шүүгчдийн бүрэлдэхүүнд 9 эрдэмтэн, зохион байгуулалтад 15 орчим хүн оролцож ажиллана.	
12.	2.5.2	Цөмийн энергийн комиссын хуралдаанд оролцох, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.	Улсын төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	2	Цөмийн энергийн комиссын 2025 оны хуралдаанаар хэлэлцэх асуудлуудын төлөвлөгөөг нэгтгэж, Цөмийн энергийн комиссын даргаар 2025 оны 01-р сарын 30-ны өдөр батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 01-р сарын 30-ны өдрийн 01/282 дугаар албан бичгээр тус комиссын Ажлын албанд хүргүүлсэн. Төлөвлөгөөний дагуу Цөмийн энергийн комисс 2025 онд нийт 3 удаа хуралдаж 10 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн бөгөөд холбогдох 5 асуудлын танилцуулга, тайланг судлан ЦЭК-ын гишүүн Эрдэс баялгийн бодлогын газрын даргад танилцуулсан.	100

13.	2.5.3	Гадаад хамтын ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах тухай санамж бичиг, гэрээ, хэлэлцээрийн төслийн санал боловсруулах.	Улсын төсөв	Боловсруулсан төслийн тоо	0	2	-Улсын Их Хурлын 2024 оны 58 дугаар тогтоолыг баримтлан Монгол Улсын Ерөнхий сайд, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд нар 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр БНХАУ-ын Харбин хотноо гарын үсэг зурсан “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөлд шаардагдах холбогдох баримт мэдээллийг боловсруулан хүргүүлж, оролцсон. “Монгол, БНСУ-ын Засгийн газар хоорондын нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэлийн ажлын хэсэгт гишүүнээр ажиллан, салбарын оролцоо болон хамтын ажиллагааны үр дүнг ханган ажиллаж байна. Геологи, ашигт малтмалын салбарт хамтран ажиллах тухай БНЭУ-ын Уул уурхайн яамтай байгуулах санамж бичиг, АНУ-ын Геологийн алба болон Монгол Улсын Үндэсний геологийн алба хооронд байгуулах санамж бичгийн төсөлд холбогдох саналыг боловсруулж, ГХАХ-т хүргүүлсэн. Росгеологи ХН, Үндэсний геологийн алба хооронд хамтран ажиллах тухай санамж бичгийн төсөлд санал өгч, холбогдох зөвшөөрлийг ГХЯ-ны ОУГЭЗГ-аас авч, санамж бичгийг 2025.01.24-ний өдөр байгуулсан. Азийн хөгжлийн банк, Бүгд Найрамдах Казахстан Улсын Аж үйлдвэр, барилгын сайд, Бүгд Найрамдах Узбекистан Улсын Уул уурхайн сайд, Исламын Бүгд Найрамдах Пакистан Улсын Эдийн засгийн сайд, Монгол Улсын Аж	100
-----	-------	---	-------------	---------------------------	---	---	--	-----

							үйлдвэр, эрдэс баялгийн сайд нар зах зээлд эрэлт хэрэгцээ ихтэй байгаа ашигт малтмалын төрөлд хамтран ажиллах тухай санамж бичиг байгуулахад бэлэн болж, зөвшөөрлийг ГХЯ-аас авсан.	
14.	2.5.4	Гадаад улс орнуудтай хамтран геологийн төслийн боловсруулах. хэрэгжүүлэх судалгааны санал	Улсын төсөв	Боловсруулсан төслийн тоо	0	2	Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийн төсөл, АНУ-ын Геологийн алба болон Монгол Улсын Үндэсний геологийн алба хооронд байгуулах санамж бичгийн төсөлд геологи, хайгуулын салбарт хамтран ажиллах саналыг боловсруулж ГХАХ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2025 оны 220 дугаар тогтоол болон “Хамтын ажиллагааны Монгол, Францын Засгийн газар хоорондын ажлын хэсгийн гуравдугаар хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-нд Монгол улсад цацраг идэвхт ашигт малтмалын цөмийн болон цацрагийн хэмжилт, шинжилгээ хийх олон улсын стандартад нийцсэн лаборатори байгуулахыг тус тус даалгасан. Тус тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд АҮЭБЯ, АМГТГ, ЦЭК-ын Ажлын албаны төлөөлөл хөрөнгө оруулагч талтай мэдээлэл солилцох, нэгдсэн ойлголцолд хүрэх уулзалтыг 2025.11.13-ны өдөр зохион байгуулж, холбогдох асуудлыг судлан орд ашиглах гэрээний төсөлд тусгасан.	100
15.	2.5.5	Геопаркийн үндэсний хорооны үйл ажиллагааг орон нутаг, оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлэх.	Улсын төсөв	Хэрэгжүүлсэн эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Геопаркийн үндэсний хорооны хуралдааныг 2025.06.13-ны өдөр зохион байгуулсан. “Соёлын болон геологийн өвөөр дамжуулан Монгол Улсад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нь” төслийн хүрээнд байгуулагдсан "Шинжлэх ухааны олон чиглэлээрх хамтарсан зөвлөл"-ийн хуралдаанд оролцож санал солилцсон. Зөвлөлөөс Геопаркийн үнэлгээний маягтын орчуулгыг сайжруулж, холбогдох байгууллагуудад хуваарилан судалгааны ажлыг	100

							гүйцэтгэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. “Соёлын болон геологийн өвөөр дамжуулан Монгол Улсад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нь” төслийн хүрээнд ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, ЮНЕСКО-ийн Зүүн Ази дахь төлөөлөгчийн газар болон Рио Тинто Монгол компани 2025.03.13-ны өдөр хамтран зохион байгуулсан төслийн олон талт оролцогч талуудын уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон. Мөн гарын авлага, лого брендинг үүсгэх төслийг эхлүүлэн ажиллаж байна. Шар цавын үлэг гүрвэлийн мөрт газрыг олон нийтэд сурталчилан таниулах, олонд танил хүмүүсээр дамжуулан танилцуулах контент бүтээх ажлыг Майнд плас ХХК-тай хамтран хэрэгжүүлсэн ба 2026 онд олон нийтийн хүртээл болсон.	
16.	2.5.6	Ховор металлын судалгааны төв байгуулах ажлыг зохион байгуулж лабораторийн үйл ажиллагааг эхлүүлэх.	Улсын төсөв	Эхлүүлсэн эсэх: (Тийм:1, Үгүй:0)	0	1	Монгол-Солонгосын Ховор металлын судалгааны төв байгуулах хамтарсан хорооны II хуралдааны бэлтгэл ажлыг зохион байгуулж БНСУ-ын Сөүл хотноо 03 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд оролцсон. Судалгааны төвийн нээлтийн ажлыг 2025.12.12-ний өдөр зохион байгуулсан бөгөөд, БНСУ-аас МУ-д суугаа элчин сайд, АҮЭБСайд нар нээж оролцсон арга хэмжээг зохион байгуулсан. Энэхүү төвд нийт 7 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг суурилуулж, 1.1 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу авах ажлыг зохион байгуулж ажилласан. Мөн төслийн удирдах хорооны хурлыг 2025.12.15-ны өдөр зохион байгуулсан.	100
17.	2.5.7	ОУАЭА-ийн зөвлөмжийн дагуу цөмийн эрчим хүчний хөтөлбөр хариуцсан нэгж (NEPIO) байгуулах шийдвэрийн санал	Улсын төсөв	Хамтран ажилласан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	0	1	ЦЭК-ийн Ажлын албатай хамтран Засгийн газрын 2024 оны хуралдааны 13 дугаар тэмдэглэлийн дагуу ОУАЭА-ийн загвараар Цөмийн эрчим хүчний хөтөлбөр хариуцсан нэгж	100

		боловсруулахад байгууллагуудтай хамтран ажиллах.					(NEPIO) байгуулах талаар танилцуулга, шийдвэрийн төслийг боловсруулсан. Цөмийн энергийн комиссын 2025.08.19-ний өдрийн хуралдаанд тус комиссын Ажлын албанаас асуудлыг танилцуулсан бөгөөд цөмийн эрчим хүчний хөтөлбөр хэрэгжүүлэх байгууллагыг байгуулах, судалгааг гүйцэтгэхэд шаардлагатай төсвийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар танилцуулж, шийдвэрлүүлэх талаар ЦЭК-ын 2025 оны 02 дугаар тогтоол гарсан.	
18.	2.5.8	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулах.	Улсын төсөв	Хуулийн хугацаанд боловсруулж хүргүүлсэн эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгах геологийн салбарын арга хэмжээний төслийн саналыг бэлтгэн, төсвийг тооцоолон Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлж ЭЗХЯ-ны холбогдох газарт тайлбар, танилцуулгыг тухай бүр хүргүүлж, хамтран ажилласан. -Монгол Улсын 2026-2030 оны Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийг боловсруулах Ажлын хэсэгт ажиллаж геологийн судалгааны ажлын төсөл, төсвийг суулгахаар хүргүүлсэн. www.invest.gov.mn цахим хуудаст төслийг багцлан оруулсан. ЭЗХСайдад 2025 оны 01/1215 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	100
Зорилт 6. Тогтвортой уул уурхай, ногоон эрчим хүчний шилжилтийг дэмжих хүрээнд чухал ашигт малтмалын талаар баримтлах бодлогыг тодорхойлно:								
19.	2.6.1	Тогтвортой уул уурхай, ногоон эрчим хүчний шилжилтийг дэмжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр бүхий л төрлийн арга хэмжээнд оролцох, зохион байгуулах.	Улсын төсөв	Оролцсон, зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	1	Монгол Улсын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Үндсэн чиглэлд туссан Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан. Монгол Улсын “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр”-ийг ахиулан шинэчлэх NDC 3.0 ажлын эхлэлийн семинарт 2025.02.04-ний өдөр оролцсон.	100

							Монгол, БНСУ хоорондын Уур амьсгалын өөрчлөлтийн зөвлөлийн анхдугаар хуралдаанд 2025.05.20-ны өдөр оролцсон. “Тогтвортой байдлын яриа, хэлэлцээ, Уур амсгалын өөрчлөлт: Тэрбум мод” олон улсын чуулга уулзалтад 2025.06.09-ны өдөр оролцсон. БОУАӨС-ын тушаалаар “Аж үйлдвэрийн салбарын үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байна. Нэгдсэн Үндэстний байгууллагын Уур амьсгалын Өөрчлөлтийн Суурь Конвенцын хэрэгжилтийн талаар Үндэсний тавдугаар тайлан илтгэл, хоёр жил дутмын ил тод байдлын 1,2 дугаар тайлан (NC5/BTR1,2) бэлтгэх төслийн “Төслийн удирдах хороо”-ны бүрэлдэхүүнд ажиллаж байна. Удирдах хорооны анхны хуралд 2025.06.04-ний өдөр оролцсон.	
20.	2.6.2	Чухал ашигт малтмалын талаар баримтлах бодлогыг тодорхойлоход холбогдох байгуулагатай хамтран ажиллах, жагсаалт батлуулах.	Улсын төсөв	Жагсаалт батлагдсан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар газрын ховор элэмент болон чухал ашигт малтмалын талаар холбогдох шийдвэрийг гаргуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/630 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, “Эрдэнэс Монгол”ХХК-иудад тодорхой үүрэг чиглэлийг өгөгдсөн. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн ажлууд хийгдэж байна. Мөн Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Критикал	100

							минералын талаар тусгай бүлэг болгон тусгасан. “Стратегийн чухал ашигт малтмалын жагсаалт батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн танилцуулга, хууль зүйн үндэслэл, тогтоолын төслийн хамрах хүрээ, практик шаардлагыг судлан боловсруулан 2025 оны 04-р сард удирдлага танилцуулсан. Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын боловсруулсан “Чухал ашигт малтмалын төсөл”-ийг дэмжих тухай анхдагч хуулийн үзэл баримтлал, анхдагч хуулийн төсөл, түүнийг дагаж бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын албан бичгээр ХЗДХЯ-нд санал хүргүүлсэн. Монгол Улсын газрын ховор элементийн өнөөгийн байдал, нөөц, судалгааны түвшин болон цаашид хэрэгжих төслүүдийн бүтээгдэхүүний бүтэц, эдийн засгийн үзүүлэлт, экспортын боломжийг нэгтгэн дүгнэх зорилгоор “Монгол Улсын газрын ховор элементийн хэтийн төлөвийн судалгаа” тайланг АМГТГ-аар боловсруулуулж, шаардлагатай дүн шинжилгээ, тооцоог багтаасан бүрэн хэмжээний тайланг 2025.12.05-ны өдөр хүлээн авсан.	
Зорилго 3. АХ-4.2.1, 4.2.24, ШСБ-3.1, 3.2, 3.1.2, МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.3.1.1, 3.3.1.2, 3.3.1.2, 3.3.1.10, 3.3.1.11, УХЖТ-ийн тэргүүлэх чиглэлийн 1.2.2.1, 1.2.2.8, 1.2.2.9, 1.2.2.10, УХЖТ-ийн 1.4.1, Геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэн, шинэ орд газруудыг нээж, газрын хэвлийн нэгдсэн геомэдээллийн санг бүрдүүлнэ.								
Зорилт 1. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн сэдэвчилсэн судалгаа, зураглал, эрэл, үнэлгээний ажлыг төлөвлөх, шаардагдах төсвийн саналыг боловсруулах, бодлого, хэтийн төлөвийг тодорхойлно:								
21.	3.1.1	Агаарын геофизикийн 1:200000-ны масштабтай цогцолбор судалгааны ажлыг гүйцэтгэх бэлтгэлийг хангах, зохион байгуулах.	Улсын төсөв	Талбайн хамрагдалт, хувиар	12.3	12.7	Өмнөд Монголын зарим хэсгийг хамарсан Агаарын геофизик-2024 төслийг 2025 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолын 2 дахь заалтын дагуу төслийн 2025 оны төсөл, төсвийг ЭБМЗ-ийн 2025 оны 04 дүгээр сарын 14-ний	-

							өдрийн хуралдаанаар хэлэлцэн УТХ-02-01 дүгнэлт гарсан. Дүгнэлтийг үндэслэн төслийн төсвийн тодотголыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/135 дугаар тушаалаар баталсан. Мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны А/91 дүгээр тушаалаар баталсан улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 136 мянган км² талбайд Агаарын геофизик-2025 төслийг шинээр эхлүүлэхээр тусган геологийн даалгаврыг батлуулсан. Улсын төсвийн хөрөнгөөр Монгол орны Хангай бүс нутагт 1:200000-ны масштабтай агаарын геофизикийн судалгааны “Агаарын геофизик-2025” төслийн ажлыг эхлүүлсэн. 1. Өмнөговь, Дорноговь, Дундговь, Баянхонгор, Өвөрхангай аймгийн зарим сумдын нутгийг хамарсан 202 мянган км² талбайд “Агаарын геофизик-2024” төслийг 2024-2025 онд хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд 2024 онд 63,000.00 км² талбайд, 2025 онд 132,780.00 км² талбайд буюу агаарын геофизикийн GravMag судалгааны болон Темпест системээр тус тус гүйцэтгэж хэмжилт хийсэн. Үүний үр дүнд нийтдээ 195,780 км.кв талбайг агаарын геофизикийн цогцолбор судалгаанд хамруулан бүрхсэн. . 2. Баруун болон Төв Монголын 136 мянган км² талбайд "Агаарын геофизик-2025" төслийг 2025 оноос шинээр хэрэгжүүлж эхэлсэн. Шинэ төслийн хүрээнд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар агаарын геофизикийн цогцолбор судалгааны хэмжилтийн нислэгийг 21,420.00 км² талбайд гүйцэтгэж, бүрхсэн байна. Төлөвлөгөөт 2025 онд нийт 154,200.00 км² талбайг буюу 9.06 хувийг агаарын геофизикийн	
--	--	--	--	--	--	--	---	--

							нислэгт хамруулж, нийт нутаг дэвсгэрийн 13.08 хувь бүрхэгдсэн байна.	
22.	3.1.2	1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.	Улсын төсөв	Талбай хамрагдалт, хувиар	47	47.5	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/189 дүгээр тушаалаар баталсан Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу геологийн 1:50 000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн 14 төслийг үргэлжлүүлэн болон шинээр эхлэн хэрэгжүүлж байна. Геологийн 1:50 000-ны иасштабтай зураглал, ерөнхий эрлийн Хайрхан Овоо-50, Их Хараат уул-50, Оорцог уул-50, Зангат-50, Модот толгой-50, Алаг баян-50, Индэртийн нуруу-50, Буйлст хүрэн-50, Хар хайрхан-50, Ямаат уул-50 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцэн хүлээн авсан. Үүний үр дүнд Монгол орны нутаг дэвсгэрийн 43055 км2 талбайг зураглал болон ерөнхий эрэлд хамруулсанаар нийт талбайн хэмжээг 2.7 хувиар нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд нийт нутаг дэвсгэрийн 49.7 хувь геологийн 1:50 000-ны масштабын зураглалаар бүрхэгдсэн.	-
23.	3.1.3	1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангах, зохион байгуулах.	Улсын төсөв	Талбай хамрагдалт, хувиар	0	0.1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны А/91 дүгээр тушаалаар баталсан Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөнд Шинэ Хархорум хотын суурьшлын бус буюу геологийн 1:25 000-ны масштабын гео-орчин болон геохимийн цогцолбор судалгааг 2025 оноос эхлэн хэрэгжүүлэхээр тусгасан. Шинэ төслийн геологийн даалгаврыг АҮЭБЯамны ТНБДаргаар батлуулсан. Төслийн гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагааг Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тухай хуулийн хүрээнд зохион байгуулсан. Тендерт шаардлага хангасан санал ирээгүй. Иймд нэгдсэн төлөвлөгөөнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны	-

							A/189 дүгээр тушаалаар тодотгол хийж, тухайн төслийг 2026 онд эхлүүлэхээр шилжүүлсэн. Иймд тухайн арга хэмжээний хэрэгжилтийг гаргах боломжгүй байна.	
24.	3.1.4	Геохимийн 1:200000-ны масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах, зохион байгуулах.	Улсын төсөв	Талбай хамрагдалт, хувиар	0	10	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны A/189 дүгээр тушаалаар баталсан Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөнд Монгол Алтайн Геохими-2025 төслийг 2025 оноос эхлэн хэрэгжүүлэхээр тусгасан. Шинэ төслийн геологийн даалгаврыг АҮЭБЯамны ТНБДаргаар батлуулсан. Төслийг Дипирамид ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 2025 онд 1.1 тэрбум төгрөгийн судалгааны ажил гүйцэтгэсэн байна. Үүний үр дүнд 41,000.00 км2 талбайг бүрхэн 4277 ш геохимийн сорьц авсан. Үүний үр дүнд нийт нутаг дэвсгэрийн 2.6 хувийг энэ төрлийн судалгаанд хамруулсан. Монгол-Алтайн геохими-2025 төслийн хээрийн материалыг 2025.11.24-ний өдөр УГА-нд хүлээн авсан.	
25.	3.1.5	Геологийн тектоник, структур, инженер-геологи, гидрогеологийн зургууд зохиох болон бусад сэдэвчилсэн судалгааны ажлуудыг гүйцэтгэх.	Улсын төсөв	Төслийн тоо	7	4	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны A/189 дүгээр тушаалаар баталсан Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөнд тусгасан Гидрогеологи-2025 төслийг шинээр хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2025 оны хээрийн судалгааг дуусган анхдагч баримт материалыг 2025 оны 11 дүгээр сарын 28-д хүлээн авсан. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 14-ний хурлаар Монгол орны босоо тэнхлэгийн дагуу гео-орчины судалгааг хийсэн Гео-Орчин-2022, 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар Баруун Монголын геологи ба шатах ашигт малтмалын судалгаа БМШАМ төслийн үр дүнгийн тайланг тус тус хэлэлцэж хүлээн авах тухай дүгнэлт гарсан. Мөн ЭБМЗ-өөр хэлэлцэн хүлээн	-

							авахаар дүгнэсэн сэдэвчилсэн судалгааны Дархан Геоэкологи-2020 төслүүдийн үр дүнг АҮЭБСайдын 2025 оны А/119 дүгээр тушаалаар хүлээн авч баталгаажуулсан. 2025 онд 4 төслийг хэрэгжүүлсэн байна.	
26.	3.1.6	Гадаад орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцан үр ашигтай геологийн шинжлэх ухааны судалгааны ажил гүйцэтгэх.	Улсын төсөв	Хамтран хэрэгжүүлсэн төслийн тоо	1	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/189 дүгээр тушаалаар баталсан Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөнд “Төв-Ази болон зэргэлдээх бүсийн геологи” төслийг ОХУ, БНХАУ, БНКаЗУ, БНСУ-ын геологийн албадтай хамтран 2025 оноос эхлэн 6 дахь шатны төслийг хэрэгжүүлэхээр тусгасан. Шинэ төслийн геологийн даалгаврыг АҮЭБЯамны ТНБДаргаар батлуулсан. Төслийг 2025 оноос хэрэгжүүлж, хээрийн тандан судалгааг БНХАУ-ын Геологийн академийн судалгааны багтай хамтран Алтай нуруунд гүйцэтгэсэн. Мөн 2025 оны 11 дүгээр сарын 13-17-ны өдрүүдэд Бээжин хотод БНХАУ-ын ШУА-ийн Геологийн академийн төслийн багтай ажлын уулзалт болж, төслийн ажлын чиглэл, хүрээг тодотгон нарийвчилсан.	-
27.	3.1.7	Үнэт, өнгөт, ховор металл, газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн геологийн судалгаа болон эрлийн ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгч баялгийн хэмжээг үнэлэх.	Улсын төсөв	Төслийн тоо	2	1	Өмнөд Монголын хэмжээнд алтны хүдэржилтийг судлах, улмаар Монгол орны алтны металлогений зургийг зохиох Мета-Алт төслийн 2025 оны төсөл, төсвийн тодотголыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/134 дугаар тушаалаар баталсан. Төслийн үр дүнгийн тайлан зохиох суурин боловсруулалтын ажил хийгдэж байна. “Монгол орны стратегийн ашигт малтмалын хэтийн төлөвийн судалгаа” ГАСАМ төслийн үр дүнг АҮЭБСайдын 2025 оны А/116 дугаар тушаалаар хүлээн авсан. Монгол орны 104 дүгээр уртрагаас зүүн талын хэсэгт 2022-2025 онд гүйцэтгэсэн өндөр технологийн түүхий эдийн судалгаа ӨТТЭ-2 болон Говь-Алтай	-

							аймгийн Баян-Уул, Шарга сумын нутгийн 2585.21 км2 талбайд эрэл, эрэл үнэлгээний ажил гүйцэтгэсэн ЭҮ-4-2022 төслийн төслийн үр дүнг ЭБМЗ-ийн 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж хүлээн авахаар дүгнэсэн. Үүний үр дүнд Өндөр Богдын талбайд Р1 зэргээр 340 кг, Ширдэгтийн талбайд мөн Р1 зэргээр 5 тонн алтны баялгийг тус тус үнэлсэн байна. Нийт 2025 онд 3 төсөл хэрэгжүүлсэн.	
Зорилго 4. АХ-4.2.1, 4.2.24, ШСБ-3.1, 3.2, 3.1.2, МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.3.1.1, 3.3.1.2, 3.3.1.2, 3.3.1.10, 3.3.1.11, УХЖТ-ийн тэргүүлэх чиглэлийн 1.2.2.1, 1.2.2.8, 1.2.2.9, 1.2.2.10, УХЖТ-ийн 1.4.1, Дорноговь аймагт дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, олон улсын стандартын шаардлага хангасан авто бензин, түлшний тодорхой хувийг дотоодоосоо хангах нөхцөлийг бүрдүүлнэ.								
Зорилт 1. ШСБ-3.3, ЗГҮАХ-3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна:								
28.	4.1.1	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж нөөцийг өсгөхөд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах.	Улсын төсөв	Дэмжлэг үзүүлсэн-1 Дэмжлэг үзүүлээгүй-0	0	1	Бүтээгдэхүүн хуваах гэрээт Төхөм Х талбайд үйл газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй Монголын Алт ХХК-ын 2024 онд хийгдсэн газрын тосны хайгуулын ажлууд, үр дүн, хэтийн төлвийг хэлэлцэж, 2025 онд хийх хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг хэлэлцэх Ажлын хэсэгт 2025 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр санал, зөвлөмж өгч, бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан. Мөн Сمارт Ойл ХХК-ийн Эргэл XII талбайн 2024 онд хийгдсэн газрын тосны хайгуулын ажлууд, үр дүн, хэтийн төлвийг хэлэлцэж, 2025 онд хийх хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг хэлэлцэх Ажлын хэсэгт 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр, Түмэн Ойл ХХК-ийн Баянтүмэн XVII талбайн 2024 онд хийгдсэн газрын тосны хайгуулын ажлууд, үр дүн, хэтийн төлвийг хэлэлцэж, 2025 онд хийх хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг хэлэлцэх Ажлын хэсэгт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр, Шунхлай Энержи ХХК ХХК-ийн Сулинхээр XXIII талбайн 2024 онд хийгдсэн газрын тосны хайгуулын ажлууд, үр дүн, хэтийн	100

							төлвийг хэлэлцэж, 2025 онд хийх хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг хэлэлцэх Ажлын хэсэгт 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр тус тус санал, зөвлөмж өгч, боддогын дэмжлэг үзүүлсэн.	
29.	4.1.2	Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах.	Улсын төсөв	Дэмжлэг үзүүлсэн-1 Дэмжлэг үзүүлээгүй-0	0	1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/198 дугаар тушаалаар Борзон VII талбайд газрын тосны хайгуулын нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, "Петроматад Энержи Лимитед" ХХК-ийг сонгон шалгаруулалтын ялагчаар тодруулсан. Үүнээс гадна, Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн "Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах эрх олгох тухай" Засгийн газрын 166 дугаар тогтоол батлагдсан. Үүний дагуу 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр "БОРЗОН VII" талбайд газрын тосны хайгуул, ашиглалттай холбоотой үйл ажиллагаа эрхлэх бүтээгдэхүүн хуваах гэрээг Ашигт малтмал, газрын тосны газар болон Петроматад Энержи Лимитед ХХК-тай байгуулж буй ёслолын арга хэмжээг нээж оролцсон. "Тэмүүжин металс" ХХК нь Уламжлалт бус газрын тосны буюу нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Ачит XXXVII талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээ 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр АМГТГ-тай байгуулсан. Тус үйл ажиллагааг яамны зүгээс нээж оролцсон. Дээрх гэрээ байгуулах үйл ажиллагаатай холбогдуулан салбарын талаар хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээлэл өгч ажиллав.	100
Зорилго 6. Эрдэс баялаг (геологи, цөмийн энерги, уул уурхай, газрын тос)-ийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохицуулахад нэгдсэн удирдлагаар хангана.								
Зорилт 1. ЗГҮАХ-ийн 3.3.1.2-д "Геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэн, шинэ орд газруудыг нээж, газрын хэвлийн нэгдсэн геомэдээллийн санг бүрдүүлнэ:								

30.	6.1.1	Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа геологийн судалгааны ажлын төслийн хээрийн судалгааны ажил, тайлан боловсруулалтын ажлын хяналт хийх.	Улсын төсөв	Төслийн тоо	0	5	Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 1:50000-ны масштабтай Ханхар уул-50, Мөст уул-50, Үүрэг нуур-50, Овоот шар-50, Баянзүрх уул-50 төслийн тайлангийн шуурхай хяналтыг 2025.11.24-25-ны өдрүүдэд хийсэн. Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 1:50000-ны масштабтай Ханхар уул-50, Мөст уул-50, Үүрэг нуур-50, Овоот шар-50, Баянзүрх уул-50 төслийн тайлангийн шуурхай хяналтыг 2025.11.24-25-ны өдрүүдэд хийсэн. Зураглалын Ямбат Уул-50, Тэх Уул-50, Таянгийн нуруу-50, Хатанхайрхан-50, Цээл-50, сэдэвчилсэн судалгааны Гидрогеологи-2025, Мета-Алт төслүүдийн 2025 оны анхдагч баримт материалыг хүлээн авах ажлын хэсэгт ажиллаж төслүүдийн материалыг хүлээн авсан.	-
31.	6.1.2	Геомэдээлллийн санг бүрдүүлэх, баяжуулах хүрээнд Чулуун сан, Цахим архив төслийн ажлын үр дүнгийн тайланг хүлээн авах.	Улсын төсөв	Төслийн тоо	1	2	Геологийн баримт-1 төслийн үр дүнгийн тайланг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/117 дугаар тушаалаар хүлээн авсан. Төслөөр геологийн судалгааны ажлын 880 тайланг цахимжуулж, геологи, эрдэс баялаг, гидрогеологи, геоэкологи, инженер геологийн сангуудыг баяжуулан, эрдэс шинжилгээний бүтээлийн цахим санг шинээр үүсгэсэн бөгөөд бусад мэдээллээр баяжуулах, шинэчлэх ажлуудыг гүйцэтгэсэн байна. -Чулуун дээжийн сан-1-2022 төслийн 2025 оны төсөл, төсвийн тодотголыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/133 дугаар тушаалаар баталсан. Төслийн үр дүнгийн тайлан зохиох суурин боловсруулалтын ажил хийгдэж байна.	-
Зорилт 2. Улсын эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах, ашигт малтмалын хайгуулын ажлыг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, уул уурхайн тогтвортой хөгжлийг хангуулах чиглэлээр бодлогын хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулна:								
32.	6.2.1	Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан хүлээн авах, хянах, ЭБМЗ-ийн	-	Нөөц бүртгэгдс	3135	3200	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024.11.30-ны өдрийн А/47 дугаартай тушаалаар Эрдэс баялгийн мэргэжлийн	-

		хурлаар хэлэлцүүлэх, холбогдох шийдвэр гаргуулах, төрөл бүрийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулах хэрэгжилтэд хяналт тавих.		эн ордын тоо			зөвлөлийн Ашигт малтмалын хайгуултай холбоотой асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн гишүүн, 2025.09.10 А/188 тушаалаар салбар зөвлөдийн даргаар ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан хэлэлцэх 17 удаагийн хуралд оролцсон. Давхардсан тоогоор 95 хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцсэн. ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцсэн ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүн, нөөцийн хэмжээний талаар мэдээлэл, танилцуулга бэлтгэн удирдлагад танилцуулсан.	
33.	6.2.3	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн геологийн судалгааны төслийн үр дүнгийн тайланг хянах, хүлээн авах, ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх, холбогдох шийдвэр гаргуулах, төрөл бүрийн мэдээ гаргах.	Улсын төсөв	Хүлээн авсан төслийн тоо	0	20	Улсын төсвийн хөрөнгөөр 2019-2024 онд хэрэгжүүлсэн 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн 9, сэдэвчилсэн судалгааны ажлын 5, нийт 14 төслийн үр дүнг ЭБМЗ-өөр хэлэлцэн геологийн даалгаварыг биелүүлсэн тухай дүгнэлт гаргасан. ЭБМЗ-ийн дүгнэлтэд үндэслэн тайлангуудыг хүлээн авах тухай шийдвэрийн төслийг боловсруулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/109-117 болон А/127-135 дугаар тушаалууд гарсан. Үр дүнгийн тайлангуудтай холбоотой мэдээллээр удирдлагыг хангаж ажилласан.	
Зорилт 7. Уурхай, уулын үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж хүлээн авах, уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авах ажлын зохион байгуулна:								
34.	6.7.1	Ашигт малтмалын орд, баяжуулах үйлдвэрийг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах, хянах, ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх, холбогдох шийдвэр гаргуулах, төрөл бүрийн мэдээ гаргах ажлыг зохион	Хувийн хөрөнгө оруулалт	Зохион байгуулсан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Ашигт малтмалын орд ашиглах, баяжуулах техник-эдийн засгийн үндэслэл хэлэлцэх хуралдаанаар 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 150 асуудлыг Эрдэс баялаг мэргэжлийн зөвлөлөөр тухай бүр хэлэлцэн шийдвэрлэсэн.	100

		байгуулах хэрэгжилтэд хяналт тавих.						
35.	6.7.2	Ашиглалтад бэлтгэсэн уурхай, уулын үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих.	Хувийн хөрөнгө оруулалт	Хүлээн авсан уурхай, баяжуулах үйлдвэрийн тоо	0	5	Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авах Улсын комисс нийт 9 удирдамжийн дагуу 30 уурхай, 4 баяжуулах үйлдвэр хүлээн авч, акт үйлдсэн. Тэсрэх материалын үйлдвэр-агуулах байнгын ашиглалтад хүлээн авах Ажлын хэсэг нийт 7 удирдажийн дагуу 9 агуулах, 21 тэсэлгээний цооног цэнэглэх төхөөрөмжид дүгнэлт гаргасан. Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Шивээговь сумдын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Эйкүсора” ХХК-ийн Өөхийн цагаан хүрэн нүүрсний ил уурхай, “Орчлон орд” ХХК-ийн эзэмшиж байгаа Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт орших зэс-алтны Оюут толгой ордын уурхайг байнгын ашиглалтад хүлээн авах Улсын комисст холбогдох албан хаагчдыг ажиллуулах Удирдамжийн дагуу ажиллуулсан.	100 ГЦЭ Хулан
Зорилт 8. Тэсрэх материалын агуулах, тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, тэсрэх материал, тэсэлгээний хэрэгслийг импортлох, тэсэлгээний ажил үйлчилгээ явуулах, тэсэлгээчний эрх олгох, сунгах үйл ажиллагааны хэрэгжилтийг зохицуулна:								
36.	6.8.1	Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, агуулахын аюулгүйн бүсийг тооцоогоор тогтоох, ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулах, хяналт тавих.	Хувийн хөрөнгө оруулалт	Аюулгүйн бүс тогтоосон актын тоо	0	5	Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн 1 үйлдвэр, 2 агуулахын аюулгүйн бүсийг тооцоогоор тогтоож, ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулсан. 2025 оны 09-өөс 12 дугаар сарын хооронд тэсрэх материалын үйлдвэр болон агуулахыг байнгын ашиглалтад хүлээн авах Ажлын хэсэг нийт 3 удирдажийн дагуу 5 тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулах, 2 тэсэлгээний цооног цэнэглэх төхөөрөмжид дүгнэлт гаргасан байна.	100
37.	6.8.2	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий мэргэжлийн	Хувийн хөрөнгө оруулалт	Олгосон, сунгасан тусгай зөвшөөрлийн	0	10	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг 5 удаагийн хурлаар тусгай зөвшөөрөл шинээр олгох болон	100

		зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих.		тоо			шинэчлэн олгох 31 асуудал, 8 тэсрэх бодисын үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж шийдвэрлэсэн.	
Зорилго 8. Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэнэ.								
38.	8.4	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг шинэчлэн боловсруулж хууль эрхзүйн актанд бүртгүүлэн, олон нийтэд нээлттэй, ил тод байдлаар сонгон шалгаруулалтыг бусад Төрийн болон Төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан хамтран зохион байгуулах, тусгай зөвшөөрөл олголтын нэмэгдүүлэх.	Улсын төсөв	Олгосон тусгай зөвшөөрлийн тоо	0	20	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох “Сонгон шалгаруулалтын журам”-ыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024.12.27-ны өдрийн А/102 дугаар тушаалаар батлуулж, ХЗДХЯ-нд хүргүүлж, 2025.01.24-ны өдөр Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 7084 дугаарт бүртгүүлсэн. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025.02.18-ны өдрийн А/33 дугаар тушаалын дагуу “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын комисс”-т ажиллаж СШ-68, СШ-71, СШ-74 кодтой сонгон шалгаруулалтаар нийт зарласан 32 талбайд ирүүлсэн оролцогчдын материалыг үнэлж 20 тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргасан.	100
39.	8.6	Бүтээн байгуулалттай холбоотой түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох асуудлыг ЗГ-ыг хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх.	Улсын төсөв	Батлуулсан эрх зүйн актын тоо	0	2	Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумаас Жаргалтхаан сум чиглэлийн 59.2 км хатуу хучилттай авто замын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицолд нэмэлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/288 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийн XVI.1.1.76-д тусгагдсан Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто зам, барилга угсралтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг нэмж батлахаар “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг	100

						боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/1159 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах зорилгоор хэрэгжүүлж буй “Газрын тос дамжуулах хоолойн төсөл”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авахаар 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 01/1427 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах зорилгоор хэрэгжүүлж буй “Газрын тос дамжуулах хоолойн төсөл”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авахаар 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 01/1426 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Бүтээн байгуулалттай холбоотой түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын 2025 оны 80, 222 дугаар тогтоолыг тус тус батлуулсан.	
Зорилго 9. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх, эрх зүйн зөвөлгөө, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, байгууллагын мэдээллийн технологийг хөгжүүлнэ.							
Зорилт 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна:							

40.	9.1.1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, тайлан, мэдээг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлэх.	Улсын төсөв	Арга хэмжээг хуулийн хугацаанд зохион байгуулсан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө- 2025, АҮЭБЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд газрын зүгээс тусгах саналыг хүргүүлэн, тухай бүр хэрэгжилтийг ТЗУГ-т хүргүүлсэн. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд салбарын зүгээс тусгах ажлыг боловсруулан нэгтгэлд (АҮБГ) хүргүүлсэн. Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд салбарын зүгээс тусгах арга хэмжээний төслийн саналыг бэлтгэн, геологийн ажлын төсвийг тооцоолон Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.	100
41.	9.1.2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөртэй уялдуулан 2025 оны үйл ажиллагааны болон холбогдох бусад төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах ажлыг зохион байгуулах.	Улсын төсөв	Арга хэмжээг хуулийн хугацаанд зохион байгуулсан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө- 2025, АҮЭБЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд газрын зүгээс тусгах саналыг хүргүүлэн, хэрэгжилтийг тухай бүр ТЗУГ-т хүргүүлсэн. Цөмийн энергийн комиссын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргын 2025 оны үр дүнгийн гэрээ, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянан, Төсвийн ерөнхийлөн	100

							захирагчаар баталгаажуулсан бөгөөд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 02/302 дугаар албан бичгээр тус Ажлын албанд хүргүүлсэн. -АҮЭБЯ-ны зүгээс Засгийн газрын 1, 2 дугаар улирлын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлын төлөвлөгөөнд тусгуулах саналыг ТЗУГ-ын Хуулийн хэлтэст тухай бүр хүргүүлсэн.	
42.	9.1.3	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас яаманд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлүүлэх, хариуг хүргүүлэх арга хэмжээ авах, холбогдох журмын дагуу хэрэгжилтийн байдлыг нэгтгэн холбогдох газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Улсын төсөв	Өргөдөл гомдлын шийдвэр лэсэн эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Тайлант хугацаанд аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудаас нийт 488 албан бичиг ирснээс 176 хариутай албан бичгээс 155 холбогдох албан тушаалтанд шилжүүлэн хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.	100
43.	9.1.4	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулж тайлагнах.	Улсын төсөв	Салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүний үүрэгт ажлын хүрээнд 2 удаа тусгай шалгалтын комисст ажилласан.	100
44.	9.1.5	Салбарын төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр боловсруулах, салбарын мэргэжлийн сургалтын байгууллага их, дээд сургууль, салбарын мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагууд, гадаад дотоодын төсөл	Сайдын багцийн холбогдох зардал болон бусад эх үүсвэрээс	Сургалт зохион байгуулсан эсэх эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Монголын геологи, хайгуул-2025 арга хэмжээний хүрээнд ШУТИС, МУИС, салбарын ААН-тэй хамтран геологичдод сургалт явуулсан. Австралийн элчин сайдад Кэйти Смит болон Австралийн Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн захиралд Сургалтын хөтөлбөрийн төсөл боловсруулж хүргүүлсэн.	100

		хөтөлбөртэй хамтран мэдлэг, ур чадвар, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах.					- Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөлөөс мэргэшсэн инженер, зөвлөх инженер олгох, сунгах батламжийг нийт 190 ирүүлснээс 116 мэргэшсэн инженерийн батламж, 74 зөвлөх инженерийн батламжийг албажуулан хүлээлгэн өгсөн. - ШУТИС-ын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 2025 оны хичээлийн жилийн хаврын улиралд бакалаврын хөтөлбөрөөр дипломын ажил, төсөл хамгаалуулах болон төсгөлтийн шалгалт авах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллан Уул уурхайн баяжуулалтын технологи мэргэжлээр 19 оюутны диплом хамгаалалтад оролцож, үнэлгээ өгсөн. - Монголын жонш олборлогч, үйлдвэрлэгч, экспортлогчдын холбооны хүсэлтийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр яамны хурлын зааланд Сангийн яам, Татварын ерөнхий газар, Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газар, Гаалийн ерөнхий газар, Гаалийн төв лаборатори болон жоншны олборлолт явуулж буй аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл оролцсон хуралдааныг зохион байгуулсан.	
45.	9.1.8	АҮЭБСайдын Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээг байгуулах, гэрээний биелэлтийн явц, хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох газарт хүргэх.	Улсын төсөв	Зохих хугацаан д нэгтгэн, хүргүүлсэн эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд болон Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээг байгуулах явцад салбартай холбоотой мэдээллийг хүргүүлэн ажилласан. Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээний биелэлтийг дүгнэх хугацаа болоогүй.	—
46.	9.1.9	Жендэрийн салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах.	Улсын төсөв	Батлуулж, хэрэгжилтийг хангасан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Жендэрийн салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний хүрээнд дараах голлох ажлуул хийгдсэн. Үүнд: 1. Төрийн захиргааны төв болон харьяа бусад байгууллагад ажиллаж буй албан хаагчдын 2025 оны статистик мэдээг 1212.mn -д оруулж цахимжуулсан.	100

							2.Жендэрийн эрх тэгш байдлыг бий болгож, бодлогыг хэрэгжүүлэхэд ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦОЛ, хамтын ажиллагаа чухал бөгөөд салбарын яамны Жендэрийн зөвлөл болон НҮБХХ-ийн менежер зөвлөхүүдтэй хамтарсан хэлэлцүүлгийг 2025 оны 3 сарын 14-ний өдөр зохион байгуулсан. 3.Монгол Улсын Засгийн Газар, Жендэрийн Үндэсний Хороо Монгол Улсын Ерөнхий сайдын 71 дүгээр захирамжаар батлагдсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)”, салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд-Түрүү булчирхайн хоргүй томролт" сэдвээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газрын албан хаагчид сургалт зохион байгуулсан. 4.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө/2022-2031/-тэй уялдуулан шинэчлэн боловсруулсан маягт, зааврын төсөлд Жендэрийн үндэсний хороонд 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 02/1437 дугаар албан бичгээр санал хүргүүлсэн. 5. “Жендэрийн эрх тэгш байдал ба уур амьсгалын өөрчлөлт олон улсын хурал”-д 2025 оны 05 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд оролцлоо. 6. Жендэрийн Үндэсний хороон дээр зохион байгуулсан яамдын жендэрийн мэргэжилтнүүдийн уулзалтад 2025 оны 4-р сарын 29-ны өдөр оролцож, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын бодлого зохицуулалтыг хангах, Хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад анхаарах асуудлын талаар хэлэлцэж, санал солилцсон.	
--	--	--	--	--	--	--	---	--

							7. Хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аянд АҮЭБЯ нэгдэх ажлыг зохион байгуулж, холбогдох мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулж, уриалгыг түгээж ажиллав. 8.ЖҮХ-той хамтран салбарын хөгжлийн түншлэгчдийн уулзалтын бэлтгэл ажлыг хангаж, 2025 оны 10-р сарын 27-ны өдөр үйл ажиллагааг зохион байгуулав. /хөтөлбөр, илтгэл, орчуулга, бусад ААН-рүү албан бичиг хүргүүлэх, донор төслүүдтэй уулзалт зохион байгуулах, оролцогчдын мэдээллийг бүрдүүлэх г.м/ 9.Эмэгтэй манлайлагчдын хамтын ажиллагааны уулзалт “Авилгын эсрэг эмэгтэйчүүдийн оролцоо манлайлал” сэдэвт уулзалтад 2025 оны 11-р сарын 27-ны өдөр оролцов. 10. Төрийн албан хаагчдын хөгжлийн клубын уулзалтад 2027 оны 11-р сарын 28-ны өдөр оролцож, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, клубын үйл ажиллагааны талаар санал солилцов.	
47.	9.1.10	Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, харъяа мэргэжлийн ангийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах.	Улсын төсөв	Хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Гамшгаас хамгаалах Аж үйлдвэр, эрдэс баялгийн Улсын албаны “Эрдэс баялгийн салбар эрсдэлийн эсрэг хамтдаа” бэлэн байдлын үзлэгт 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр оролцсон бөгөөд Улсын албаанаас байгууллагыг 76 хувьтай үнэлсэн.	100
48.	9.1.11	“Mining week-2025” арга хэмжээг зохион байгуулах	Улсын төсөв	Зохион байгуулсан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци хамтран “MiningWeek & MinePro 2025” олон улсын уул уурхайн үзэсгэлэн, чуулга уулзалт дөрөв дэх жилдээ зохион байгуулагдсан. “Эрдэс баялгийн салбарын шинэ мөчлөг: Хөрөнгө оруулалт ба хариуцлагатай уул уурхай” сэдвийн дор 9 дүгээр сарын 11-13-ны өдөр Налайх дүүргийн Тайж Хайрханы бэлд амжилттай зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд 20 гаруй улсын 350 гаруй байгууллагуудын 20,000	100

							/давхардсан тоогоор/ орчин зочин төлөөлөгчдийн хүрээнд зохион байгуулагдлаа. Эрдэс баялгийн салбарын шинэ мөчлөг: “Хөрөнгө оруулалт ба хариуцлагатай уул уурхай” уриан дор өрнөж, салбарын өнөөгийн нөхцөл байдал болон ирээдүйн хөгжилд нэн чухал асуудлуудыг олон улсын болон дотоодын оролцогч талуудын оролцоотойгоор хэлэлцэх боломж нөхцөлийг бүрдүүлэн ажилласан. Уга арга хэмжээний хүрээнд үйлдвэржилт, хариуцлагатай уул уурхай, хөрөнгө оруулалт, олон улсын чиг хандлага, геологийн судалгаа, хайгуул, шинэ эрчим хүч, дэвшилтэт технологи зэрэг 13 салбар хуралдаан болж, нийт 77 илтгэл хэлэлцсэн.	
Зорилт 2. Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, давхардал хийдлийг арилгах, хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгоно:								
49.	9.2.1	УИХ-ын чуулган, Байнгын хороо, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлыг боловсруулан, холбогдох газарт хүргүүлэх.	Улсын төсөв	Хүргүүлс эн эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	12	УИХ-ын чуулган, Байнгын хороо, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлыг боловсруулан, холбогдох газарт хүргүүлэх ажлын хүрээнд дараах асуудлууд хийгдсэн Үүнд: - Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл; - Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд хэлэлцээр байгуулахтай холбоотой асуудлаар протоколыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замыг холбох Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл;	100

							- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл; - Засгийн газрын хуралдаанаар Оюутолгой төслийн тулгамдсан асуудлууд цаашид авах арга хэмжээний талаарх асуудал; - Стратегийн ач холбогдол бүхий Оюу толгойн бүлэг ордод тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа Онпре ХХК-ийн эзэмшиж байгаа ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талаарх танилцуулга; Монгол Улсын Эрдэс баялгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар танилцуулгыг бэлтгэн 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 01/740 дугаартай албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын 2025.03.12-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Танилцуулгад Геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлын тухай, Уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспорт, төсвийн орлого гүйцэтгэл, Газрын тосны хайгуул, ашиглалтын нөхцөл байдал, Боловсруулах салбарын өнөөгийн байдал, Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт гэсэн үндсэн 10 хэсгээс бүрдэнэ. - Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, Хилийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.2-т заасныг тус тус үндэслэн “Хилийн зурвастай давхцалтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаа явуулах эрх олгох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг холбогдох материалын хамт боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 01/1589 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	
--	--	--	--	--	--	--	---	--

						- Бүтээн байгуулалттай холбоотой түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох асуудлаар 2 Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2025 оны 80, 222 дугаар тогтоолыг тус тус батлуулсан. - “Ашигт малтмалын зарим тусгай зөвшөөрлийн тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/478 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын 2025 оны 13 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. - Улсын төсвийн хөрөнгөөр сүүлийн 5 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн геологийн судалгааны ажлын үр дүн, цаашид авах арга хэмжээний тухай мэдээлэл бэлтгэн танилцуулсан. - Монгол Улсын Эрдэс баялгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар танилцуулгыг бэлтгэн Засгийн газрын 2025.03.12-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. - “Ашигт малтмалын зарим тусгай зөвшөөрлийн тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/478 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын 2025 оны 13 дугаар тэмдэглэл гарсан. УИХ-ын Төсвийн байнгын хорооны даргын захирамжаар УИХ-ын гишүүн Д.Заяабалын ахалсан ажлын хэсгээс ирүүлсэн улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа геологийн судалгааны ажилтай холбоотой асуулга болон хүсэлтийн дагуу мэдээллийг бэлтгэн хүргүүлсэн. Тус ажлын хэсгийн гишүүдэд салбарын үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлын талдаар танилцуулга хийж, ТБХ-ны тогтоолын төсөл боловсруулан хүргүүлсэн.	
--	--	--	--	--	--	---	--

50.	9.2.2	Засгийн газар болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Төрийн нарийн бичгийн даргыг шүүхэд итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөн оролцох.	Улсын төсөв	Төлөөлсөн эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Засгийн газар болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Төрийн нарийн бичгийн даргыг шүүхэд итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөн оролцох чиглэлээр төлөвлөсөн ажлын хүрээнд “Бичигт хайрхан трейд” ХХК, “Энержи Ресурс” ХХК, “Алтайн хүдэр” ХХК-иудын Монгол Улсын Засгийн газарт холбогдуулан гаргасан гурван захиргааны хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, шүүх хуралдаанд бүрэн төлөөлөн ажилласан.	100
51.	9.2.3	Төрийн болон албаны нууцын хамгаалалтыг зохион байгуулж хэрэгжүүлэх, хяналт тавих.	Улсын төсөв	Хэрэгжилтийг хангасан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Төрийн болон албаны нууцын хамгаалалтад хяналт тавих ажлыг тухай бүр хийж гүйцэтгэн, байнга сануулж ажилласан.	100
Зорилт 3. Салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын эрх зүй, туршлагыг судлах, санал гаргах, дэмжлэг үзүүлнэ:								
52.	9.3.2	Гадаад орны Засгийн газрын төлөөлөгчидтэй хийх уулзалт болон олон улсын хурал, чуулганд оролцох.	-	Оролцсон эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Гадаад орны Засгийн газрын төлөөлөгчидтэй хийх уулзалт болон олон улсын хурал, чуулганд оролцох чиглэлээр төлөвлөсөн ажлын хүрээнд Монгол, Францын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны Ажлын хэсгийн III дугаар хуралдааны удирдамж, яриа хэлэлцээний сэдэв, түүнтэй холбоотой цөмийн энергийн салбарын саналуудыг тусгаж 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Гадаад харилцааны хэлтэст хүргүүлэн бэлтгэл ажлыг ханган ажиллав. Мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд болон Төрийн нарийн бичгийн дарга гадаад орны Засгийн газрын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтуудад оролцон яриа хэлэлцээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны бодит ажиллагаанд идэвхтэй оролцлоо. Үүнээс гадна Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Засгийн газар хооронд хэрэгжүүлж буй “Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл” буюу	

							Хамтарсан кредит олгох механизмын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж, олон улсын хамтын ажиллагааны бодлогын хэрэгжилтэд хувь нэмэр оруулан ажилласан.	
53.	9.3.3	АҮЭБЯ-ны удирдлагуудыг гадаад орны дипломат төлөөлөгчийн газар (ЭСЯ, ОУБ, бусад байгууллага)-ын тэргүүн, гадаад орны төлөөлөгчидтэй хийх уулзалтад оролцох.	-	Оролцсон эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны удирдлагуудыг гадаад орны дипломат төлөөлөгчийн газар болон олон улсын байгууллагын тэргүүн, төлөөлөгчидтэй хийх уулзалтад оролцуулах чиглэлээр төлөвлөсөн ажлын хүрээнд Гашуунсухайт–Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд байгуулах хэлэлцээртэй холбоотой асуудлаар холбогдох албан тушаалтнуудтай хамтран ажиллаж, уулзалтын бэлтгэл болон яриа хэлэлцээг дэмжин оролцсон. Мөн Монгол Улс, ИБУИНХУ-ын Дугуй ширээний XV уулзалтад болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 03 дугаар сарын 13–14-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Польш Улсад хийх айлчлалын бэлтгэл ажлын хүрээнд Элчин сайд Н.Оюундарийн Польшийн холбогдох сайд нартай хийх уулзалтын ярианы сэдэв, түүнчлэн Монгол–Оросын Засгийн газар хоорондын комиссын Газрын хэвлийн ашиглалтын хамтарсан дэд комиссын хуралдааны сэдэвтэй холбогдох саналуудыг тусган боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан.	100
Зорилт 5. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын багцын төсвийн гүйцэтгэл 2024 онд 95 хувь байсныг 2024 онд 2.0 хувиар нэмэгдүүлж, төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлнэ:								
54.	9.5.1	АҮЭБСайд /төсвийн ерөнхийлөн захирагч/-ын 2026 оны төсвийн төсөл, 2026-2027 оны дунд	-	Шийдвэр лүүлсэн эсэх	0	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2026 оны төсвийн төсөл, 2026-2027 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026 оны төсвийн	100

		хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026 оны төсвийн хязгаарын санал, 2026 оны төсвийн төслийг боловсруулж батлуулах.		(Тийм:1, Үгүй:0)			хязгаарын саналыг боловсруулан Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.	
55.	9.5.2	АҮЭБСайд /төсвийн ерөнхийлөн захирагч/-ын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн ил тод байдлыг хангаж ажиллах.	Улсын төсөв	Хуулийн хугацаанд зохион байгуулж ил тод байдлыг хангасан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	АҮЭБСайд /төсвийн ерөнхийлөн захирагч/-ын эрхлэх асуудлын хүрээнд яам болон ҮГА-наас зохион байгуулсан 3 удаагын худалдан авах ажиллагааг удирдлан зохион байгуулсан. Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж гэрээ байгуулах эрх авсан оролцогчийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим сайтад байршуулан ажилласан.	100
Зорилт 6. Салбарын гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, дэмжих чиглэлээр санал боловсруулах, олон улсын хамтын ажиллагааны байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлнэ:								
56.	9.6.3	Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээс эрдэс баялгийн салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэхтэй холбогдуулан төслийн нэгжүүдтэй хамтран ажиллах.	Улсын төсөв	Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо	0	1	Геологи, цөмийн энергин салбарт гадаад улсын зээл, тусламжийн эх үүсвэр, эсхүл хамтран хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийн төсөлд санал өгсөн. Австралийн элчин сайдад Кэйти Смит болон Австралийн Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн захиралд Сургалтын хөтөлбөрийн төсөл боловсруулж хүргүүлсэн.	-

МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ:

Д/д	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэх ажил	Эхлэх, дуусах огноо
0	1	2	3	4

“Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” зорилтын хүрээнд:

1	Хариуцсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн богино хугацааны сургалтад хамрагдсан байна. Шалгуур: Тийм-1, Үгүй-0	1	Яам, агентлаг, бусад төрийн байгууллага, мэргэжлийн холбоодоос зохион байгуулсан сургалтад албан хаагчдыг хамруулсан.	I-IV улирал
---	--	---	---	-------------

Төлөвлөгөөг үнэлсэн:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

.....
(огноо)

Төсвийн шууд захирагч

/Б.ДАШПҮРЭВ/

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

.....
(огноо)

Нэгжийн дарга

/Ө.ӨНӨРНАСАН/

Тайлагнасан:

УУЛ УУРХАЙН БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

.....
(огноо)

Нэгжийн дарга

/Г.НАМЧИНСҮРЭН/